



ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА

“МУИС-ийн хөгжилд-Миний
/бидний/ оролцоо”
сэдэвт эссэ бичлэгийн
уралдааны
УДИРДАМЖ



ЗОРИЛГО

МУИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, стратегийн тэргүүлэх чиглэлүүд, үнэт зүйлс, сургуулиараа бахархах сэтгэл, үзэл санааг МУИС-ийн оюутан бүрт ухамсарлуулан хоногшуулах, оролцоог хангах

ХАМРАХ ХҮРЭЭ

МУИС-ийн оюутан, оюутнуудын баг, оюутны холбоод, клубүүд

ЭССЭНИЙ ЧИГЛЭЛ

- Дэлхийн түвшний их сургууль болоход миний /бидний/ оролцоо
- Дэлхийн түвшний их сургуульд сурах, төгсөх нь миний /бидний/ хичээл, сурлага, ажил, амьдралд хэрхэн нөлөөлөх

ЭССЭНД ТАВИГДАХ АГУУЛГЫН ШААРДЛАГА

- Шинэлэг санаа, тодорхой асуудлыг дэвшүүлсэн байх
- Асуудлыг зөв тодорхойлсон, логик уялдаатай байх
- Сонгосон сэдвийн хүрээнд үндсэн санааг тодорхойлохдоо онол, практикийн талаас судалсан байх, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон байх

ЭССЭНД ТАВИГДАХ ХЭЛБЭРИЙН ШААРДЛАГА

- Цаасны хэмжээ: А4
- Хуудасны тоо: 4-6 /нүүр, ашигласан материалаас гадна/
- Үсгийн фонт: Arial
- Үсгийн хэмжээ: 12
- Мөр хоорондын зай: 1.5

БУСАД ШААРДЛАГА

- Эх хэлний дүрмийн болон хэл найруулга, логикийн алдаагүй байх;
- Ашигласан ном, зохиолын эх сурвалжийг заавал дурдсан байх;
- Эссэний нүүрэнд овог, нэр, сургууль, холбоо барих утас, и-мэйл хаягаа тодорхой бичсэн байх;
- Эссэг хугацаа хожимдуулалгүй өгөх.

ЭССЭГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулна.

- I шатанд эссэ бичлэгийг хүлээн авч, шүүгчдийн бүрэлдэхүүн оноо өгөх журмаар шилдэг 5 эссэ бичлэгийг II шатанд оролцуулахаар шалгаруулна.
- II шатанд шалгарсан 5 эссэ бичлэгийг шалгарагчаар /баг/ илтгэл тавиулж байр эзлүүлнэ.
- Шалгаруулалтын хугацааг тухай бүрт и-мэйлээр өгнө.

ШАГНАЛЫН САН

- I байр - Өргөмжлөл, дурсгалын зүйл, 300 000 төгрөг
- II байр - Өргөмжлөл, дурсгалын зүйл, 200 000 төгрөг
- III байр - Өргөмжлөл, дурсгалын зүйл, 100 000 төгрөг
- Шагналт IV, V байр - Өргөмжлөл, дурсгалын зүйл, тус бүр 50 000 төгрөг

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА, ХАЯГ

- 2018 оны 4 дүгээр сарын 9-ний өдрөөс 4 дүгээр сарын 27-ны өдрийн 14.00 цаг хүртэл МУИС-ийн 1-р байр, 219 тоот.
- Эссэг 1 хувь хэвлэж ирүүлэх ба эхийг файл хэлбэрээр доорх цахим хаягаар явуулсан байна.

Оюутан залуус та бүхнийг уралдаанд идэвхтэй оролцож, өөрсдийн мэдлэг, чадвараа сорихыг уриалж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах утас: 75754400, 77307730-1160,1162, 99018393, 99072004, ganba@num.edu.mn, ganba8899@gmail.com и-мэйлээр авна.

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС

2018 он